



УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН ХУРЛЫН ТЭМДЭГЛЭЛ

2025 оны 06 дугаар сарын 22

Дугаар 02

Улаанбаатар хот

УЛСЫН ОНЦГОЙ КОМИССЫН II ХУРАЛДААН

Улсын онцгой комиссын хуралдаан 2025 оны 06 дугаар сарын 22-ны өдрийн 11.00 цагт Төрийн ордон дахь “Чингис хаан танхим”-д 94% хувийн ирцтэй хуралдав.

Хуралдааныг Монгол Улсын Шадар сайд, Улсын онцгой комиссын дарга С.Амарсайхан даргалж, холбогдох шийдвэрийг гаргаж, үүрэг даалгавар өгөв.

ХЭЛЭЛЦСЭН АСУУДАЛ:

1. Улаанбурхан өвчний нөхцөл байдал, цаашид авч хэрэгжүүлэх арга хэмжээний талаар

Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэн

2. Ган, зуншлагын нөхцөл байдал, зуны улирлын цаг агаарын төлөв, анхаарах асуудал

*Цаг уур, орчны шинжилгээний газрын дарга,
Улсын онцгой комиссын гишүүн Э.Баттулга*

3. Бусад

Гамшгаас хамгаалах тухай хуулийн 27¹ дүгээр зүйлийн 27^{1.1}-д заасныг үндэслэн ШИЙДВЭРЛЭСЭН НЬ:

Нэг. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэнд:

1.1. Гамшгаас хамгаалах тухай хууль, Монгол Улсын Шадар сайдын 2025 оны 01 дүгээр сарын 29-ний өдрийн 15 дугаар тушаалаар батлагдсан “Гамшгаас хамгаалах улсын албаны ажиллах нийтлэг журам”-д заасны дагуу эрүүл мэндийн салбарын хэмжээнд гамшгаас хамгаалах өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжүүлж улаанбурхан өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг хязгаарлах хариу арга хэмжээг эрчимжүүлэх, шаардлагатай хүний нөөцийг дайчлан ажиллуулах, үндэсний товллын болон нөхөн дархлаажуулалтын хамрагдалт, эмнэлгийн тусламж үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх арга хэмжээг шуурхай авч хэрэгжүүлэх;

Хоёр. Улсын онцгой комиссын гишүүд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

2.1. Эрүүл мэндийн салбарын хэмжээнд өндөржүүлсэн бэлэн байдлын зэрэгт шилжсэн хугацаанд улаанбурхан өвчний үндэсний товллын болон нөхөн дархлаажуулалтын хамрагдалтыг нэмэгдүүлэх, тухайн өвчнөөс урьдчилан сэргийлэх, тархалтыг хязгаарлах чиглэлээр эрүүл мэндийн байгууллагаас зохион байгуулж буй үйл ажиллагаанд бүх талаар дэмжлэг үзүүлэх, хамтран ажиллах;

Гурав. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэн, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

3.1. Бүх шатны эрүүл мэндийн байгууллагад тандалт, хариу арга хэмжээ, эмнэлгийн тусламж үйлчилгээ, дархлаажуулалт, лабораторийн чиглэлээр цахим сургалтыг зохион байгуулж зөвлөмж, мэдээлэл өгөх;

3.2. Эрсдэлт бүлгийн хүн ам ялангуяа бага насны хүүхэд, өндөр настнууд дунд тандалтыг эрчимжүүлэх, эмнэлгийн тусламж үйлчилгээг сайжруулах, гэрийн эргэлт, хяналтыг идэвхжүүлэх;

3.3. Улаанбурхан өвчний дэгдэлтийн үед авах хариу арга хэмжээний төлөвлөлтийг сайжруулж, шаардлагатай эм, эмнэлгийн хэрэгсэл, оношлуур, вакцин, тоног төхөөрөмж, хүний нөөцийг бүрдүүлж, бэлэн байдлыг хангаж ажиллах;

3.5. Улаанбурхан өвчний эсрэг нөхөн дархлаажуулалтыг эрчимжүүлж, “Хаалганаас хаалганд” зарчмыг баримтлан дархлаажуулалтаас хоцорсон хүүхдийг нөхөн дархлаажуулах;

Дөрөв. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэн, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Н.Баасандамба, Монголын үндэсний олон нийтийн радио, телевизийн ерөнхий захирал, Улсын онцгой комиссын гишүүн Г.Гэрэл, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

4.1. Улаанбурхан өвчний халдвараас урьдчилан сэргийлэх, халдварын эсрэг дархлаажуулалтад олон нийтийг идэвхитэй хамрагдах чиглэлээр мэргэжлийн байгууллагуудтай хамтран зөвлөмж, уриалга, сэрэмжлүүлэг мэдээ, мэдээллийг

тогтмол түгээх, олон нийтэд буруу ташаа мэдээлэл тархахаас сэргийлэх арга хэмжээ авах;

Тав. Сангийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Б.Жавхлан, Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэн болон аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

5.1. Улаанбурхан өвчний тандалт, дархлаажуулалт, урьдчилан сэргийлэх арга хэмжээний бэлэн байдлыг хангах, хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэхэд шаардлагатай хөрөнгийг нэн даруй шийдвэрлэх;

Зургаа. Цахим хөгжил, инновац, харилцаа холбооны сайд, Улсын онцгой комиссын гишүүн Э.Батшугар, Тагнуулын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, хошууч генерал П.Одонбаатар, Цагдаагийн ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн, бригадын генерал Т.Сүхболд нарт:

6.1. Үндэсний товлот дархлаажуулалт, вакцины талаар олон нийтэд зориудаар хуурамч, мэдээ, мэдээлэл түгээж хүн амын эрүүл мэндийн аюулгүй байдалд сөрөг нөлөөлөл үзүүлж буй этгээдүүдийг олж тогтоох, таслан зогсоох, холбогдох хууль журмын дагуу хариуцлага тооцох;

Долоо. Засгийн газрын хэрэгжүүлэгч агентлаг, Улсын бүртгэлийн ерөнхий газрын даргын үүргийг түр орлон гүйцэтгэгч Д.Даваанямд:

7.1. Заавал хийх үндэсний товллын дагуу дархлаажуулалтад хамрагдах 0-15 настай хүүхдийн одоогийн оршин суугаа хаягийг тогтооход Халдварт өвчин судлалын үндэсний төв болон аймаг, нийслэлийн Эрүүл мэндийн газарт дэмжлэг үзүүлж, хамтран ажиллах;

Найм. Эрүүл мэндийн сайд, Улсын онцгой комиссын гишүүн Ж.Чинбүрэн, Боловсролын сайд П.Наранбаяр, Боловсролын яамны Төрийн Нарийн бичгийн дарга, Улсын онцгой комиссын гишүүн Х.Батжаргал, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

8.1. Хичээлийн шинэ жил эхлэхэд улаанбурхан өвчний халдварын тархалт нэмэгдэхээс урьдчилан сэргийлэх арга хэмжээг эртнээс авч хэрэгжүүлэх, салбарын хэмжээнд эрсдэлийн үнэлгээ хийх, багш, сурагчдыг халдварын эсрэг дархлаажуулалтад хамрагдсан эсэхийг нотлох баримтыг хянах;

8.2. Цэцэрлэг, ерөнхий боловсролын сургуульд суурилсан дархлаажуулалтыг хамтран зохион байгуулах;

Ес. Улсын онцгой комиссын гишүүн, Барилга, хот байгуулалтын сайд Э.Бат-Амгалан, Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, ЗГХЭГ-ын Хэвлэл мэдээлэл, Олон нийттэй харилцах газрын дарга, Улсын онцгой комиссын гишүүн Н.Баасандамба, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

9.1. Улсын онцгой комиссын 2025 оны 02 дугаар албан даалгавар, Монгол Улсын Шадар сайдын 2025 онд баталсан “Үер, усны ослын эрсдэлийг бууруулах, урьдчилан сэргийлэх нэгдсэн арга хэмжээний удирдамж”-ийн хэрэгжилтийг хангаж ажиллах;

9.2. Цаг уурын байгууллагаас гаргасан ус, цаг агаарын гаралтай аюулт болон гамшигт үзэгдлийн талаарх мэдээллийг бүх төрлийн хэвлэл, мэдээллийн хэрэгслээр иргэд, олон нийтэд шуурхай тогтмол хүргэх ажлыг өргөн хүрээтэйгээр зохион байгуулах;

9.3. Гол, мөрөн, нуурын эрэг, тогтоол усны орчимд иргэд олноор цугларсан газруудад хөдөлгөөнт эргүүлийг хууль сахиулах болон гамшгаас хамгаалах орон нутгийн албад, аж ахуйн нэгж, байгууллагуудтай хамтран ажиллуулах. Үүнд: нисгэгчгүй нисэх төхөөрөмж, камерын хяналтыг иж бүрэн ашиглах;

9.4. Гол, мөрөн, нуур, цөөрмийн тохой, эрэг дагуу болон уулын ам, бэл, гуу жалга, судгийн аманд айл өрх суурьшихгүй байхыг анхааруулах, аж ахуйн нэгж үйл ажиллагаа явуулахыг хориглох, эрсдэл бүхий газар нутагласан айл өрхөд мэдэгдэл, албан шаардлага хүргүүлэх, нэн шаардлагатай тохиолдолд шуурхай нүүлгэн шилжүүлэх;

9.5. Төв, суурин газрын үерээс хамгаалах инженерийн дэд бүтэц, далан, суваг, шуудууг сэргээн засварлаж, үерийн ус нэвтрэх чадварыг сайжруулах, хэвийн ажиллагааг хангахад шаардлагатай төсөв хөрөнгийг шийдвэрлэх;

9.6. Үер, уруйн үер, хүчтэй салхи шуурга, мөндөр, хүйтэн бороо, хэт халалт зэрэг цаг агаарын аюулт гамшигт үзэгдэл тохиолдсон үед хариу арга хэмжээ авч хэрэгжүүлэх ашиглах техник, багаж хэрэгсэл, тоног төхөөрөмж, хүн нэг бүрийн хамгаалах хувцас хэрэглэлийн бэлэн байдлыг хангуулах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх;

Арав. Улсын онцгой комиссын гишүүд, Гамшгаас хамгаалах улсын албад, бүх шатны төрийн байгууллагууд, аймаг, нийслэл, сум, дүүргийн Засаг дарга нарт:

10.1. 2025-2026 оны өвөлжилт, хаваржилтын бэлтгэл ажлыг эртнээс төлөвлөн, хэрэгжилтийг хангаж ажиллах;

10.2. Аймаг, сумын аюулгүйн нөөцөд өвс, тэжээл бэлтгэх ажлыг зохион байгуулах, зуншлага тааруу, хадлан бэлтгэх боломжгүй аймаг, сумд бусад аймаг, орон нутгаас өвс тэжээл бэлтгэх, худалдан авах ажлыг яаралтай зохион байгуулах;

10.3. Олон улс, бүс нутагт үүссэн хямралт нөхцөл байдал, түүнээс шалтгаалан учирч болох эрсдэл, сөрөг нөлөөллийг хариуцсан салбарын хэмжээнд үнэлж, авч хэрэгжүүлэх хариу арга хэмжээний төлөвлөлтийг гаргах, шаардлагатай нөөцийг бүрдүүлэх ажлыг нэн даруй зохион байгуулах;

Шийдвэрийн биелэлтэд хяналт тавьж, тухай бүр танилцуулж ажиллахыг Онцгой байдлын ерөнхий газрын дарга, Улсын онцгой комиссын орлогч дарга, хошууч генерал Г.Ариунбуян, Улсын онцгой комиссын Нарийн бичгийн дарга, хурандаа Т.Баярхүү нарт даалгах.

ДАРГА

С.АМАРСАЙХАН

НАРИЙН БИЧГИЙН ДАРГА,
ХУРАНДАА

Т.БАЯРХҮҮ

